



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 141

Баянхутаг сум

**“СУМЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ” СУРГУУЛИЙН
БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ АЖЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339, 340 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй газар хөдлөлтийн стратегийн команд штабын сургалттай холбогдлуудан сумын иргэдийн иргэдийн түр цугларах талбайг тэмдэгжүүлж, иргэдэд сурталчилгааны ажил зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Наранбадрап – Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: А.Чимэддондов – Нийгмийн ажилтан

Гишүүд: Г.Болд – Засаг даргын тамгын газрын дарга

Ц.Ганзориг – Эрүүл мэндийн төвийн эрхлэгч

Г.Ганболд – ЕБС-ийн захирал

Т.Наранцэцэг – Цэцэрлэгийн эрхлэгч

С.Мөнххэрлэн – Соёлын төвийн дарга

Д.Буянбат – Жаргалант багийн Засаг дарга

Д.Алтанчимэг – Улаан-Өндөр багийн Засаг дарга

Б.Алтангэрэл – Цантын хоолой багийн Засаг дарга

М.Содгэрэл – ХЭХАХМэргэжилтэн

Б.Тожилсүрэн – Тархвар зүйч

Б.Баярмагнай – Газрын даамал

Д.Отгонбат – Улсын бүртгэгч

Б.Заяабаатар – Хэсгийн төлөөлөгч

3. Сумыг нүүлгэн шилжүүлэх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, иргэдийн түр цугларах талбайг тэмдэгжүүлэх ажлын байршлыг 2 дугаар хавсралтаар, нүүн шилжүүлэх дадлага сургалтад иргэдийг хамруулах бүртгэл хийх ажлын хэсгийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж тайланг онцгой байдлын газарт хугацаанд нь хүргүүлэхийг нарийн бичгийн дарга (А.Чимэддондов), Сумын Засаг даргын орлогч (С.Наранбадрал) нарт даалгасугай.

ДАРГА  Б.БАЙГАЛМАА

232501071